



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

200 /200/

2021.12.14

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

САНХҮҮЧИД СПОРТООР ӨРСӨЛДӨЖ, ШИЛДГҮҮДЭЭ ТОРУУЛАВ



Монгол Улсад Санхүү, эдийн засгийн байгууллага үүсэн байгуулагдсаны 110 жилийн ой, "Бүртгэл санхүү, эдийн засгийн ажилтны өдөр"-ийг тохиолдуулан Батлан хамгаалах салбарын бүртгэл санхүүгийн ажилтнуудын дунд зохион байгуулсан гар бөмбөг, ширээний теннисний тэмцээнд 16 багийн 130 орчим санхүүч оролцон хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Тэмцээнийг БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга хурандаа Д.Ганбат, ЗХЖШ-ын Санхүүгийн хэлтсийн дарга хурандаа Б.Бүрэнтөгс нар нээж баг тамирчдад амжилт хүссэн юм. Тэмцээний холимог гар бөмбөгийн төрлөөр Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн

санхүүгийн дарга хошууч Ч.Чинбат, БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн хурандаа М.Амаржаргал, АЦК-ын Санхүүгийн хэлтсийн дарга хурандаа П.Дэлгэр ахлагчтай багууд эхний гурван байрыг эзлэв. Ширээний теннисний эрэгтэй төрлөөр дэслэгч М.Лачингарав /310/, дэд хурандаа С.Түвшинтөгс /БХЯ/, ахлах дэслэгч Ч.Хангай /142/ нар бусдыгаа хошуучилсан бол эмэгтэй төрлөөр Н.Энхмаа /089/, ахмад Ч.Оюунцэцэг /124/, Ж.Амаржаргал /БХЯ/ нар эхний байруудад шалгарсан юм.

Тэмцээний нийлбэр дүнгээр ахмад Ч.Оюунцэцэг ахлагчтай Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн баг тамирчид хошуучилж шилжин явах цомын эзэд боллоо.

1954 он.

ЦЯЯ-ны дарга нарын хэрэг эрхлэх шинэ хүчний хэлтэс офицерын боловсон хүчний тасаг болов.

2005 он.

Сьерра Леон дахь Бүсийн тусгай шүүхийн хамгаалалтын үүргийг Монголын цэргийн багаар гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг Монгол Улсын Засгийн газар 225 дугаар тогтоолоор гаргажээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-12	-24


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.0	2,851.0
EUR	3,179.0	3,250.0
CNY	445.30	448.60
RUB	38.10	39.50
JPY	24.77	25.36
KRW	2.36	2.45

ЗУРХАЙ



2021.12.14 МЯГМАР ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 11/

ИРЭХ ОНЫ ТӨСВӨӨ БАТЛУУЛАВ

ХОЛБООНЫ АЛБА ХОШУУЧИЛЛАА



Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/4 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд орон нутагт батлан хамгаалах хууль тогтоомж, бодлого, зорилтыг хэрэгжүүлэхээр 1.194 сая төгрөгийг батлуулаад байна.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус аймгийн нутаг дэвсгэрт байрлан

үйл ажиллагаа явуулж буй Зэвсэгт хүчний анги, салбаруудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр тусгасан ба 2022 онд 1.01 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахаар төсөвлөөд байна. Тухайлбал, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Зэвсэгт хүчний 167 дугаар ангид 1.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий цэргийн гал тогоог 2023 онд ашиглалтад оруулахаар төлөвлөөд байгаа ба 2022 онд 900.0 сая төгрөгийг шийдвэрлэн ажлыг эхлүүлэхээр боллоо.

Дэд хурандаа Б.БЭРХГАЛТ

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

2021-2022 оны сургуулийн жилийн алба, салбар сурталчлах аян Зэвсгийн албаны сурталчилгаагаар үргэлжилж байна. Энэ хүрээнд нэгтгэлийн нийт бие бүрэлдэхүүнтэй цэрэг спортын уралдаан тэмцээнүүдийг амжилттай явууллаа. Байнгын бүрэлдэхүүний тэмцээнд мотобуудлагын батальон,

ажиллагааны удирдлагын тасаг, холбооны албаны багууд эхний байруудад шалгарсан бол ХЦАХ-аас танкийн батальон, артиллерийн дивизион, зенитийн артиллерийн батареины багууд эхний байруудад шалгарч алт, мөнгө, хүрэл, медалийн эзэд боллоо. Үргэлжлүүлээд энэ 7 хоногт тагнуул, хими, инженерийн албадууд албаа сурталчлахаар шилжин явах тугаа гардан авлаа.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
374.040 +296

ВАКЦИНЖУУЛАЛТ
2,156,656 +532

НАС БАРСАН
1,965 +2

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6706 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
145

ЭДГЭРСЭН
6433

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 271,097,024

Эдгэрсэн
Нийт: 243,754,350

Нас барсан
Нийт: 5,328,507

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САР ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ УЛААН БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Эрхтэн хурц болно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.34-16.59

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал:

Ус

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нгууд бүтээхэд сайн, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн.

Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэзэгт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

цаг үе, үйл явдал

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНД МАНЛАЙЛАВ



Зэвсэгт хүчний 327 дугаар анги
ААрдын хувьсгалын 100 жилийн ойн хүрээнд Дорнод аймгийн иргэд, нийтийг бие тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлэх, коронавирус /COVID-19/-ын талаар хүн амын эрүүл мэндийн мэдлэг

боловсролыг дээшлүүлж, биеийн дархлааг дэмжих зорилгоор аймгийн Биеийн тамир, спортын газраас зохион байгуулсан "Иргэдийн наадам-21" спортын цогцолбор тэмцээнийг зохион байгуулав. Тус тэмцээнд БНМАУ-ын баатар, ЗХУ-ын

4 удаагийн баатар, маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн баг тамирчид олс таталт, өртөөт марафон, сагс болон гар бөмбөгийн төрлөөр өрсөлдөн багаараа тэргүүн байр эзэлж цомын эзэд боллоо.



НОМТОЙ ӨГЛӨӨ ...



Дорнод аймгийн Төв номын сантай хамтран ажиллах гэрээний дагуу хугацаат цэргийн алба хаагчдын оюунд хөрөнгө оруулах, тэдний албандаа хандах хандлага, цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх, хувь хүний хөгжлийг дээшлүүлж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор өнгөрөгч амралтын өдрүүдэд "Номтой өглөө" хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Хэлэлцүүлгээр "Хагацашгүй" романаас сэдэвлэсэн танин мэдэхүйн

тэмцээнийг зохион байгуулсны дээр зөврийн номын санг ажиллуулан Төв номын сангийн үзэсгэлэнг

ангийн байрлалд дэлгэж бие бүрэлдэхүүний оюуны мэдлэгийг тэллээ.

Ахмад Д.ГАНБААТАР



2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ТАЙЛАГНАЖ, ИРЭХ ОНЫ АЖЛАА ТӨЛӨВЛӨВ



Зэвсэгт хүчний 353 дугаар анги

Ангийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурал боллоо. Тайлангийн хуралд Зэвсэгт хүчний АЦК-ын АДХ-ын хэлтсийн дарга хурандаа Э.Батсайхан, Зенит пуужингийн ахлах офицер-ерөнхий инженер хурандаа Т.Энхбат нар оролцлоо. Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн захирагч хурандаа Ш.Аюурзана ангийн 2021 оны үйл ажиллагааны тайланг илтгэж, 2022 онд дэвшүүлсэн зорилго, зорилтыг танилцуулсны дараа хурандаа Э.Батсайхан ангийн бие бүрэлдэхүүнд АЦК-аас дэвшүүлсэн зорилго, зорилтыг танилцуулж, хамт олны санал, сэтгэгдлийг сонсон, шийдвэр гаргах

түвшинд уламжлахаа мэдэгдэн энэхүү хурал өндөрлөлөө.

Мөн тус анги Монгол Улсад санхүүгийн алба үүсэн байгуулагдсаны 110 жилийн ойн хүрээнд тус ангийн санхүүгийн албанаас бие бүрэлдэхүүний дунд ширээний теннисний тэмцээнийг эрэгтэй, эмэгтэй ангиллаар зохион байгууллаа. Тэмцээний

эрэгтэй төрлийн тэргүүн байрт 324 дүгээр дивизионы дэд ахлагч Б.Бердибек, дэд байрт ХКБ-ны ахлагч Б.Энхбаатар, гутгаар байрт Инженер пуужингийн албаны инженер ахмад П.Мөнхбаатар нар шалгарсан бол эмэгтэй төрөлд П.Анужин, ХКБ-ны ахлагч Б.Жаргалзаяа, Г.Мөнх-эрдэнэ эхний байруудыг эзэллээ.



ТАСАГ, АЛБА, САЛБАР СУРТАЛЧЛАХ АЯНЫГ ӨРНҮҮЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Ангийн тасаг, алба, салбар сурталчлах аян энэ сарын 7-ны өдрөөс штабын албадуудаас эхэлсэн бөгөөд 7 хоногийн турш үргэлжиллээ. Энэ хүрээнд тасаг, алба, салбаруудын танилцуулгыг хийж, бие бүрэлдэхүүнийг

цаг үеийн мэдээллээр хангав. Мөн ангийн аварга шалгаруулах буудлагын болон гар бөмбөгийн тэмцээн, урлагийн хэсэгчилсэн тоглолт, бүжгийн үдэшлэг зэрэг ажлуудыг өрнүүлэв.

Буудлагын тэмцээнд 12 баг оролцсоноос тэргүүн байрт 32 оноогоор ахлах ахлагч Б.Бямбабаяр,

ахлагч О.Ганцацрал нар, гар бөмбөгийн тэмцээнд хошууч Б.Отгонжаргал ахлагчтай штабын II баг тэргүүн байрыг тус тус эзэллээ. Мөн бүтээлч ажил болгож сургалт бэлтгэлийн бэлэн байдлыг хангах зорилгоор ангийн сургалтын албанд GPS хандивлав.

Дэслэгч Р.БИЛЭГ



Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)